

Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 4/36 дугаар тушаалын хавсралт

Хамрах хүрээ: “Амгалан дулааны станц” ХХК-ны нийт ажиллагсад	Хариуцах ЗУХэлтэс	ЭЗЭН:
Хүчинтэй хугацаа: 2016.02.15 - 2018.12.31	Танилцах: Бүх ажиллагсад	
Хувийг хадгалах: Захиргаа удирдлагын хэлтэс	Хуудасны тоо: 05	

### Мансууруулах бодис, согтууруулах ундааны эсрэг бодлого, мэдээлэл

“Амгалан дулааны станц” ХХК-ийн нийт ажилтнуудыг зохистой мэдээлэл, зааварчилгаа, сургалт, удирдлагаар хангаж хүн бүр аюулгүй ажиллах нөхцөлийг бий болгох үүднээс ажлын байраа мансууруулах бодис болон согтууруулах ундаанаас ангид байлгахыг зорьж байна.

Энэ хүрээнд бид дараах бодлогыг дэвшүүлж байна. Үүнд:

1. МУ-д мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөж хэвшүүлэх
2. Аюулгүй үйлдвэрлэл явуулах боломж нөхцлийг бүрдүүлэн болзошгүй аливаа аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд ажилтнуудыг мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхгүй хамт олон болгох
3. “Аюулгүй байдлыг хангасны дараа ажлаа эхэлье” гэсэн уриаг ажилдаа чиг үүрэг болгох

#### 1. Шалгалт, үзлэгийг явуулах зарим эрх бүхий ажилтнууд:

Мансууруулах бодис, согтууруулах ундааны талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн мэдээллийг Захиргаа удирдлагын хэлтэс болон ХАБЭА-н инженер, Сургалт хариуцсан ажилтаны сургалтаар дамжуулан нийт ажилчдад хүргэх болно. Мансууруулах болон согтууруулах бодисын тогтмол болон гэнэтийн үзлэг, шалгалтыг эрх бүхий доорхи хүмүүс ажил эхлэхийн өмнө ба ажлын явцад хийнэ. Үүнд:

- “Амгалан дулааны станц” ХХК-ний Удирдлагууд
- “Амгалан дулааны станц” ХХК-ний ХАБЭА-н инженер



- “Амгалан дулааны станц” ХХК-ний Цех, нэгжийн дарга нар, ашиглалтын инженерүүд
- Харуул хамгаалалтын албаны ажилтан

## 2. Шалгалт, үзлэгт хамрагдах хүрээ, давтамж:

Энэхүү “Мансууруулах бодис, согтууруулах ундааны талаар баримтлах бодлого”-ыг “Амгалан дулааны станц” ХХК-нд ажиллаж байгаа нийт ажиллагсад дагаж мөрдөх ба тогтмол болон гэнэтийн үзлэг, шалгалтыг хийх эрх бүхий хүмүүсийн тавьсан шаардлагын дагуу үзлэгт хамрагдах шаардлагатай.

Автомашин жолоодож замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нар аюулгүй байдлын үүднээс ажил эхлэхийн өмнө зайлшгүй үзлэгт хамрагдана.

Үзлэгийг доорхи зохицуулалтаар хийнэ.

### Тогтмол үзлэгийг:

- “Амгалан дулааны станц” ХХК-ний жолооч нарт Авто инженер ашиглалтын инженерүүд:
- “Амгалан дулааны станц” ХХК-ний өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэж байгаа ажилтнуудад Цех, нэгжийн дарга нар, ашиглалтын инженерүүд тус тус ажил эхлэхийн өмнө хийнэ.

### Гэнэтийн үзлэг гэдэгт доорхи нөхцөлийг ойлгоно:

- Гэнэтийн- Хэзээ ч авч болзошгүй энэ тест-ийг өгөх нь компаний ажиллагсадын үүрэг.
- Шалтгаантай хардалт – ИТА нар нь ажилтныг зөрчил гаргасан байх магадлалтай гэж үзвэл тестийг авна.

### “Амгалан дулааны станц” ХХК-ийн ХАБЭА-н инженер нь:

- Дулааны станцад ажиллаж байгаа ажилтнуудыг шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд
- Зам тээврийн осол гарсан тохиолдолд
- Амраад ирж байгаа ажилтныг шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдол бүрд

### Тест өгөхөөс татгалзах

Хэрэв ажилчид согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах тест өгөхөөс татгалзвал тест сөрөг гарсан гэж тооцох бөгөөд хариуцлага тооцох болно.

гаар.....  
**ДУЛААН**  
**ХХК**  
**ИБАР Ү**  
 сон ажилтны  
 .....  
 ... сарын ..

### Сайн дураар тест өгөх

Ажилчид нь өөрийгөө ажилд гарахад тэнцэхгүй гэж ухамсарлан сайн дураараа энэхүү тестэд хамрагдсан тохиолдолд тухайн өдрийн ажлаас чөлөөлнө.

### 3. Хориглох зүйлс

- Ажилчид 0.01-ээс 0.05 хүртэл согтолттой тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэж болохгүй. Энэхүү зөрчлийг гаргасан ажилтан байгууллагын дотоод журмын дагуу сануулах хүртэл арга хэмжээ эсвэл Архидан согтууруулахтай тэмцэх тухай хууль дагуу арга хэмжээнүүдийг авна.
- Жолооч нь кабиндаа согтууруулах ундаа болон мансууруулах бодис хадгалах
- Ажилчид нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний тестийг ямар нэгэн ослын дараа, гэнэтийн үед өгөхөд татгалзах эрхгүй.
- Мансууруулах бодис хэрэглэсэн ажилтан ажилд гарч болохгүй. Хэрэв ажилтан нь тайвшруулах болон унтуулах үйлчилгээтэй эм хэрэглэж байгаа тохиолдолд зайлшгүй ХАБЭА-н инженер, шууд удирдлага болон эмчид мэдэгдэх үүрэгтэй ба ямар нэгэн гаж нөлөөгүй зөвлөсөн тохиолдолд ажилд гарахыг зөвшөөрнө.
- Эмчийн бусдад бичсэн мансууруулах бодисыг өөр этгээд хэрэглэсэн тохиолдолд хориотой мансууруулах бодис хэрэглэсэнд тооцно.
- 2013 оны 3 сарын 1 ны өдөр батлагдсан “Тамхины хяналтын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйл болох Утаат тамхи татахыг хориглох цэгүүдэд тамхи татах, зөвшөөрсөн цэгээс өөр газар, ажлын байруудад тамхи татахыг хориглоно.

### 4. Хүлээх хариуцлага

- Мансууруулах бодис болон согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг алхоль хэмжигчээр шалгана. Ажлаа гүйцэтгэхэд ажилтаны цусан дахь согтолтын хэмжээ 0.00 хэмжээтэй байх шаардлагатай.
- Ажилчид 0.01-ээс 0.05 хүртэл согтолттой тохиолдол зөрчлийг үйлдсэн этгээдийг байгууллагын дотоод журмын дагуу шат дараалсан арга хэмжээ авна. Тухайн зөрчлийг 2 ба түүнээс дээш гарвал ажлаас халах шууд шалтгаан болно.
- Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг зөрчсөн ажилтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгууллагын удирдлагын зүгээс хуулийн хүрээнд захиргааны шийтгэл ногдуулна.

## **Тестийн үйл явц**

Бүх тестийг энэхүү “Мансууруулах бодис, согтууруулах ундааны талаар баримтлах бодлого”-ын дагуу зохион явуулна. Эдгээр үе шат нь тестэд хамрагдаж байгаа этгээдийг хамгаалах үүднээс тестийн үйл явцад шударга зарчим баримтлана.

## **5. Мэдээлэл**

Доорхи хэсэгт согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэснээс үүдсэн шинж тэмдэг болон үр нөлөөний талаар дурьдсан болно.

### **Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн хүний шинж тэмдэг**

#### **Шинж тэмдэг, Хэрэглээ, үр дүн**

**Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн хүний ерөнхий шинж тэмдэг:**

- Харьцааны доголдол гаргах
- Уур уцаартай болох
- Анхаарал муудах
- Өгсөн зааврыг мартаx
- Шүүмжлэлийг өөрт тусгаж авах
- Ямар нэг асуудлыг няцаах
- Ажлын идэвхи суларч, анхаарал болгоомжгүй болох

### **Согтууруулах ундаа**

#### **Шинж тэмдэг**

- Сульдах
- Бувтнаж ярих
- Хүндрэлтэй алхах
- Чичрэх
- Самуурах
- Хордлогод өртөх
- Архи үнэртэх

ИЦ

ЭГ

...

)

## Мансууруулах бодис

### Шинж тэмдэг

- Самуурах
- Нойргүйдэх
- Хий юм харах
- Толгой өвдөх
- Уур уцаартай болох
- Тааламжгүй үнэртэй болох

### Хэрэглээ, үр дагавар

- Эм хэрэглэсэн; ханиалганы сироп уусан
- Донтуулна; удамшлын байх магадлалтай
- Дүнсгэр, сэтгэл санааны хувьд тогтворгүй
- Осолд өртөмтгий, аливаа зүйлээс цочимтгой болох
- Зожиг, догшин, хэт яриа болох

Бүртгэлийн дугаар .....

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ХХК

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

20 16 оны 18 сарын 18 -ний өдөр